



**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН-2024**

2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

Энэхүү үнэлгээний тайланд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 1-д заасан тайлангийн маягт болон Монголын хөрөнгийн биржийн 2022 оны 6-р сарын 9-ний өдөр баталсан үнэлгээний аргачлалыг тус тус баримтлав.

Үнэлгээний асуулгын бүтэц

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6
4	Аудит, хяналтын тогтолцоо	6
5	Эрсдэлийн удирдлага	8
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6
7	Оролцогч талуудын эрх ашиг	8
8	Компанийн соёл	6
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10
	Нэгдсэн дүн	72

Үнэлгээний оноо

- ✓ Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо;
- ✓ Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо;
- ✓ Хэрэгжүүлээгүй, үнэлгээ ирүүлээгүй бол 0 оноо.

Нэгдсэн үнэлгээ

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ.

- ✓ Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- ✓ 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсэж болзошгүй тул Монголын хөрөнгийн биржээс зөвлөмж хүргүүлэх;
- ✓ 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул Монголын хөрөнгийн биржээс зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- ✓ 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзнэ.

Үнэлгээний асуулга

Компанийн засаглалын үнэлгээний асуулга				
<p>Кссексийн хэрэгжлтийг "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгав.</p>				
НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ				
<p>ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, харааг бус байдал зэргийг зохиистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.</p>				
№	Зүйл	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмад ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан бөгөөд компанийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршсан болно. ТУЗ-ийн гишүүдийн эрх, үүргийг журмын 6 дугаар бүлэгт, ТУЗ-ийн даргын эрх, үүргийг журмын 7 дугаар бүлэгт, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг журмын 8 дугаар бүлэг, хариуцлагатай холбоотой зохицуулалтыг журмын 11 дүгээр бүлэгт тус тус зохицуулсан.	2	100%
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	Компани нь ТУЗ-өөс баталсан ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журмад болон Залгамж халааны бодлогыг тус тус үйл ажиллагаандаа мөрддөг. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журмаар ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшиж буй этгээдэд тавигдах шаардлага, ТУЗ-ийн гишүүнийг сонгох, түүнчлэн улируулан томилохтой холбоотой асуудлыг зохицуулсан. Харин залгамж халааны бодлогоор компанийн эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны төлөвлөгөө, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд авах арга хэмжээний талаар нарийвчлан зохицуулсан бөгөөд компанийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршсан болно.	2	100%

<p>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</p>	<p>Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын ажлын туршлага, боловсролын мэдээлэл, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хэмжээг тусгаж, компанийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан болно.</p>	<p>2</p>	<p>100%</p>
<p>1.4. Компани нь ТУЗ-ийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</p>	<p>Компани нь ТУЗ-ийн болон түүний дэргэдэх дараах хороодын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан тус бүрийн журамтай бөгөөд компанийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ТУЗ-ийн үйл ажиллагааны журам - ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журам - ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журам - ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны журам - ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны журам - ТУЗ-ийн дэргэдэх Тогтвортой байдлын хорооны журам (Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 12 тоот тогтоолоор байгуулагдсан байнгын хороо болно. ТУЗ-ийн тогтоолыг хавсаргав) <p>Мөн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны журмын 7 дугаар бүлэгт ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшиж байгаа этгээдийн боловсрол, мэргэжил, туршлага, ур чадварт тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах талаар нарийвчлан тусгасан.</p> <p>Бодлогын баримт бичиг гэдэг нь тухайн үйл ажиллагаанд хамаарах зарчмыг тодорхойлох үндсэн баримт бичиг бөгөөд журам үүнд хамаарах тул ТУЗ-ийн болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам нь энэ зүйлд заасан бодлогын баримт бичиг болно.</p>	<p>2</p>	<p>100%</p>
<p>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ</p>	<p>ТУЗ-ийн гишүүдийн 2023 оны сургалтын тайлан, 2024 оны сургалтын төлөвлөгөөг хавсаргав.</p>	<p>2</p>	<p>100%</p>

	гүйцэтгэхэд шаардлагагүй ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.			
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг, харууцлагыг нарийвчлан тусгасан бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаанд ТУЗ-ийн дарга хяналт тавьж ажилладаг.	2	100%
ДҮН 12 100%				
ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ				
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн харууцлагыг хүлээнэ				
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хэрэгжүүлсэн	2	100%
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжүүлсэн	2	100%

	<p>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</p>	Хэрэгжүүлсэн	<p>хорооны журам нь энэ зүйлд заасан бодлогын баримт бичиг болно.</p> <p>ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны гишүүдэд ТУЗ-ийн 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн №27 тоот тогтоолоос гишүүдийн бүрэлдэхүүнд хойш өөрчлөлт ороогүй болно.</p>	2	100%
9	<p>Хурмын 4.6 дахь хэсэгт Цалин урамшууллын хорооны хуралд хорооны гишүүдээс өөр этгээд оролцох эрхгүй бөгөөд компанийн гүйцэтгэх захирал болон бусад этгээд урилгаар оролцдог.</p> <p>ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны гишүүдийг томилсон ТУЗ-ийн 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн №27 тоот тогтоолоос хойш гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.</p>	Хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журмын 2.2 дахь хэсэгт хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн байхыг тодорхойлж, ТУЗ-ийн дарга нь хорооны даргаар ажиллахыг хориглосон.</p>	2	100%
10	<p>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</p>	Хэрэгжүүлсэн	<p>Компани нь ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам болон Залгамж халааны бодлогын баримт бичигтэй бөгөөд компанийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан болно.</p> <p>Нэр дэвшүүлэх хорооны журмын 2.2 дахь хэсэгт хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн байхыг тодорхойлж, ТУЗ-ийн дарга нь хорооны даргаар ажиллахыг хориглосон.</p> <p>ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны гишүүдийг томилсон ТУЗ-ийн 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн №27 тоот тогтоолоос хойш гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.</p>	2	100%

11	<p>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</p>	Хэрэгжүүлсэн	<p>Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 12 тоот тогтоолоор Тогтвортой байдлын байнгын хороог байгуулсан.</p> <p>Компани нь ТУЗ-ийн дэргэдэх нийт 6 байнгын хороогой ажиллаж байна.</p>	2	100%
<p>ДУН 10</p>					
<p>ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</p>					
<p>ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана</p>					
12	<p>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p>	Хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 07-ны өдрийн №35 тоот тогтоолоор Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталсан бөгөөд үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	2	100%
13	<p>3.2. ТУЗ нь энэхүү кодекс заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</p>	Хэрэгжүүлсэн	<p>Компанийн цахим хуудсанд байрлах Хөрөнгө оруулагч цэсний Компанийн засаглал хэсэгт гэх цонхны дүрэм, журам хэмээн нэрлэсэн засаглалын баримт бичиг, бодлого, журмууд нээлттэй байршсан болно.</p> <p>Тухайн мэдээлэлд орсон өөрчлөлт бүрийг тухай шинэчлэх үүргийг компанийн Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмаар зохицуулж байна.</p>	2	100%
14	<p>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл</p>	Хэрэгжүүлсэн	<p>Компани нь санхүүгийн бүртгэл, тайлагналын ажиллагаага олон улсын стандарт, дотоодын хууль тогтоомжинд заасны дагуу зохион байгуулдаг тул санхүүгийн тайлан нь тэнцвэртэй, тодорхой, бодит байх шаардлагыг хангасан.</p>	2	100%

	<p>ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</p>		<p>Компанийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө бүхий үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг эрмэлздэг. Компани нь Байгаль орчин, нийгмийн бодлоготой бөгөөд уг бодлогын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудыг улирал бүр үйл ажиллагааны тайландаа тусгадаг бөгөөд 2023 онд Байгаль орчин, нийгэм засаглалын тайлангаа олон нийтэд мэдээлсэн.</p>	<p>6</p>	<p>100%</p>
<p align="center">ДҮН</p>					
<p align="center">ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТЛОЦОО</p>					
<p align="center">ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</p>					
<p>15</p>	<p>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.</p>	<p>Хэрэгжүүлсэн</p>	<p>ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журмын 7 дугаар бүлэгт хөндлөнгийн аудитортой харьцах, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах талаар нарийвчлан тусгасан.</p> <p>Аудитын хорооны үйл ажиллагааны журмын 8 дугаар бүлэгт зааснаар Хорооны нарийн бичгийн дарга нь хорооны хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн бүх гишүүн, аудит болон Гүйцэтгэх удирдлагад хүргүүлднэ. Аудитын хороо нь ТУЗ-ийн ээлжит хурлаар хийсэн ажлаа ТУЗ-д тайлагнана хэмээн тодорхойлсон.</p>	<p>2</p>	<p>100%</p>
<p>16</p>	<p>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</p>	<p>Хэрэгжүүлсэн</p>	<p>Кодекс хэрэгжиж эхэлснээс хойш Хувьцаа эзэмшигчдийн хуралд хөндлөнгийн аудиторыг хяналт хэрэгжүүлэх зорилгоор байлцуулдаг болсон.</p> <p>Компанийн 2024 оны 4 сарын 29-ний өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Ингүүмэл Жаргалант Аудит ХХК хөндлөнгийн аудит оролцуулж, хурлын үйл явц, зохион байгуулалттай холбоотой аудитын дүгнэлт гаргуулсан. Дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тайлангай хамт СЗХ болон МХБ-д эх хувиар хүргүүлсэн болно.</p>	<p>2</p>	<p>100%</p>

17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийгэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	Хэрэгжүүлсэн	Дотоод аудитын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж, <u>ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН</u> . ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журам, хорооны гишүүд болон Дотоод аудитын газрын захирлын мэдээллийг цахим хуудсанд нээлттэй ил тод байршуулсан.	2	100%
ТАВДУГААР ЗАРЧИМ: ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон компанийн хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны журмаас гадна ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 20 тоот тогтоолоор батлагдсан <u>Эрсдэлийн удирдлагын бодлогыг</u> баримтлан ажилладаг.</p> <p>Уг бодлогын 7.2 дахь хэсэгт зааснаар Компанийн эрсдэлийн тайланг улирал бүр ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороонд танилцуулах, дүгнэлт гаргуулах, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь ТУЗ-д танилцуулахаар зохицуулсан.</p> <p>ТУЗ -ийн Эрсдэлийн удирдлагын хороо нь байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоонд өндөр түвшиний чиглүүлэг хяналт хийхээс гадна, Эрсдэлийн удирдлагын тогтолцооны Хамгаалалтын 3 бүсийн зарчмын дагуу байгууллагын Дотоод аудитын газар нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдлыг хараат бусаар үнэлж ТУЗ-д тайлагнадаг.</p>	2	100%
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас	Хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийг томилсон ТУЗ-ийн 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн	2	100%

	<p>доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</p>		<p>№27 тоот тогтоолоос хойш, гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.</p> <p>ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг байгууллагын цахим хуудасд байршуулсан байдаг.</p> <p>МХБ-д байршуулсан 2023 оны үйл ажиллагааны тайлан ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийн танилцуулгыг оруулсан.</p>		
20	<p>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</p>	Хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-өөс баталсан “Байгаль орчин, нийгмийн бодлого”-ын хүрээнд компанийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлж, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд 2022 болон 2023 онуудын Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайланг байршуулсан.</p>	2	100%
21	<p>5.4. Компани нь компайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба компайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</p>	Хэрэгжүүлсэн	<p>ББСБ нь компайнсын хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий зарчмыг ББСБ-ын Эрсдэлийн удирдлагын бодлогоор тодорхойлсон. Бодлогын хүрээнд хянан нийцүүлэлт буюу байгууллагын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх чиг үүрэгтэй эгтгэдээр хамгаалалтын хоёрдугаар бүс болох Эрсдэлийн удирдлага, комплаенсын газрыг тодорхойлсон. Уг бодлогыг ТУЗ баталдаг. Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогыг ТУЗ баталсан бөгөөд бодлогын хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг. Мөн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын хөтөлбөрийг Гүйцэтгэх удирдлагаар багтуулан бүхий л үйл ажиллагаандаа баримтлан ажилладаг.</p> <p>Бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс ББСБ нь Хуулийн нийцлийн үнэлгээ хийх зааврыг баталж, үйл ажиллагаандаа</p>	2	100%

			<p>мерддөг. Уг зааврын хэрэгжилтэд Гүйцэтгэх удирдлага хяналт тавих бөгөөд хэрэгжилтийн үр дүнд ТУЗ хяналт тавьдаг. Түүнчлэн ББСБ нь Шүгэл үлээх журамтай бөгөөд уг журмаар компанийн ажилтнууд хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм, журмыг зөрчсөн үйлдлийг илрүүлэх, тухайн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх асуудлыг зохицуулсан болно.</p> <p>Эрсдэлийн удирдлагын бодлогоор эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурладаг бөгөөд үүний дагуу компанийн холбогдох газрууд хамгаалалтыг хэрэгжүүлдэг. Хуулийн нийцлийн үнэлгээний журмын дагуу Хууль эрх зүйн алба нь компанийн үйл ажиллагаа болон дүрэм журмуудад үнэлгээ хийж ажилладаг. Шүгэл үлээх журмын дагуу Дотоод аудитын газар нь компанийн ажилтнуудын зүй бус үйлдэл, дотоод дүрэм журам зөрчсөн үйлдлийг шалгаж шийдвэрлэдэг. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогод заасны дагуу компанийнсын ажилтан нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ажилладаг. Компанийн компанийнсын ажилтныг томилсон Гүйцэтгэх захирлын тушаалыг хавсаргав.</p>		
			ДҮН	8	100%
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ: ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, хэлбэр, эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны журамд заасны дагуу аудитын хорооны гишүүдийн саналыг үндэслэн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох, хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцүүлдэг.	2	100%

			2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдсан ТУЗ-ийн үйл ажиллагааны жилийн төсөвт, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоосон болно. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэртэй <u>үйл дарж танилцана уу.</u>		
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	Хэрэгжүүлсэн	Компани нь “Ажилтны цалин хөлс, хөнгөлөлт хангамж, цалин урамшууллын журам” болон “Ажилтны үнэлгээний журам”-тай бөгөөд уг журмуудаар компанийн бүх ажилтнуудын цалин хөлс, урамшуулал тооцох арга, хэлбэр, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур зэргийг зохицуулсан.	2	100%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.		Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал олгох гүйцэтгэлийн шалгуурыг 2022 оны үйл ажиллагааны тайланд тусгаж, цахим хуудсанд байршуулсан. 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд мөн тусгаж, компанийн цахим хуудсанд байршуулах болно.	2	100%
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр баталсан <u>Харилцагчийг хамгаалах бодлого нь</u> компанийн цахим хуудаст нээлттэй байршсан. Мөн засаглалын кодекс заасан бүхий л бодлогын баримт бичгүүд болон компанийн удирдлагаас гарч буй шийдвэрүүдийн үндсэн зарчим нь харилцагч, хөрөнгө оруулагч, ажилтнуудын эрх ашгийг хамгаалах, мэдээлэл ил тод нээлттэй байх зарчимд тулгуурласан байдаг.	2	100%

26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Хэрэгжүүлсэн	Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд болон 2023 оны Байгаль орчин, нийгэм засаглалын тайланд компанийн оролцогч талууд болох хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмигчид, харилцагчид, ажилтнууд болон зохицуулагч байгууллагуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн тоо баримт, мэдээллүүдийг нэгтгэн оруулсан.	2	100%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Хэрэгжүүлсэн	Компанийн бусад оролцогч талуудтай хамтран ажиллах, тэдгээрийн санал хүсэлтийг хүлээн зорилготой “хүсэлт илгээх” цонхыг ажилуулж, тухай бүр хариу өгч ажилладаг. Түүнчлэн цахим хуудаснаас гадна facebook chatbot, Instagram зэрэг олон нийтийн сүлжээгээр харилцагчидтай холбогдож ажилладаг. Цаашид илүү сайжруулж ажиллахаар төлөвлөж байна.	2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Хэрэгжүүлсэн	Компани нь Шүгэл үлээх журам, Хөдөлмөрийн дотоод журам болон Сургалт, хөгжлийн журамтай. Шүгэл үлээх журмаар компанийн ажилтнууд хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм, журмыг зөрсөн үйлдлийг илрүүлэх, тухайн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх асуудлыг зохицуулсан. Түүнчлэн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтнууд ажил олгогчид өргөдөл, хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх процессыг тодорхойлсон. Ажилтны нийгмийн асуудлыг шийдэх талаар Ажилтны хөнгөлөлт, хангамжийн журамд тусгасан. Сургалт хөгжлийн журмаар ажилтны мэргэжил дээшлүүлэх, тасралтгүй хөгжих боломжийг бий болгосон. Байгууллагын 2023 оны сургалтын төлөвлөгөө болон хэрэгжилтийн тайланг үнэлгээнд хавсаргав.	2	100%
			ДҮН	8	100%
НАЙМДУГААР ЗАРЧИМ КОМПАНИЙН СОЁЛ					

ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно

29	<p>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагаатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	<p>Компани нь ТУЗ-өөс баталсан Бизнесийн ёс зүйн дүрэм болон Ажилтны ёс зүйн дүрмийг тус тус 2022 оноос хойш дагаж мөрдөн ажиллаж байна.</p> <p>Дээрх ёс зүйн дүрмүүдийг шинэ ажилтны сургалтын хөтөлбөр, ТУЗ-ийн гишүүдийн сургалтын хөтөлбөр, мөн жил бүрийн хүний нөөцийн газрыг нийтийг хамарсан сургалтын хөтөлбөрт тусгасан байдаг.</p> <p>Мөн ёс зүйн дүрмүүдийн хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьж ажилладаг бөгөөд компанийн зүгээс ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гүйцэтгэх захирлын дэргэдэх Ёс зүйн хороог байгуулан, улирал бүрийн тайлангаа ТУЗ-ийн танилцуулдаг байхаар ёс зүйн хорооны журмыг батлахаар ажиллаж байна.</p>	2	100%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Хэрэгжүүлсэн	<p>Компанийн ТУЗ-өөс батлагдсан Шүгэл үлээх журам нь компанийн цахим хуудсанд байршсан.</p> <p>Шүгэл үлээх журмын хэрэгжилтэд ТУЗ хяналт тавин ажиллаж байна.</p>	2	100%
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Хэрэгжүүлсэн	<p>Авлига, хээл хахууль болон ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглахтай холбоотой харилцааг Бизнесийн ёс зүйн дүрэм болон Ажилтны ёс зүйн дүрэмд дэлгэрэнгүй зохицуулсан.</p> <p>Мөн Ажилтны ёс зүйн дүрэм болон Бизнесийн ёс зүйн дүрмийн зөрчил нь сахилгын зөрчилд тооцогддог болно.</p>	2	100%
			ДҮН	6	100%

ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана

32	<p>9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.</p>	Хэрэгжүүлсэн	<p>Компани нь үйл ажиллагааны тайлангаа улирал тутам, санхүүгийн тайлангаа жил бүр, Тогтвортой байдлын тайланг жил бүр өөрийн цахим хуудас болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагчид болон олон нийтэд хүргэдэг.</p> <p>Компанийн цахим хуудасны тайлан болон компанийн засаглал хэсэгт үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, засаглалын талаарх мэдээллийг авч болно.</p>	2	100%
33	<p>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</p>	Хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 07-ны өдрийн №35 тоот тогтоолоор <u>Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөрийг баталсан.</u></p> <p>Мөн цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагчаар <u>БҮРТҮҮЛЭХ, САЛБАРУУЛСНЫ ХАЯГ БАЙРШЛЫН МЭДЭЭЛЭЛ, ВЭБ ХУУДСААР НЭВТРЭХ</u> цонхоор дамжин өөрийн эзэмшдэг үнэт цаас болон компаниас авсан санхүүгийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэлтэй танилцах, хүсэлт гаргах, холбоо барих боломжтой.</p> <p>Мөн Инвескор аппликейшныг 2023 оны 12 дугаар сараас эхлэн нэвтрүүлж, харилцагч, хөрөнгө оруулагчдад санал болгон ажиллаж байна.</p>	2	100%
34	<p>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	Хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-аас баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журмаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх, хуралд биечлэн болон зайнаас, хосолсон хэлбэрээр оролцох, хэлэлцсэн асуудалд санал өгөх, хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл авах зэрэг хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх эрхийг олгосон.</p> <p>Мөн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурлыг өөрсдийн Инвескор аппликейшн болон вэб хуудсаар дамжуулсан нь хувьцаа эзэмшигчдийг мэдээлэл хүлээн авах, зайнаас оролцох,</p>	2	100%

			<p>асуулт асуух, хурлын материалтай танилцах боломжуудыг бүрэн олгосон.</p> <p>СЗХ-ны Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд заасан нөхцөл шаардлага, хугацаатай үүргүүдийг бүрэн биелүүлэн ажиллаж, хурлын тайланг СЗХ-нд хүргүүлж, хянуулсан болно.</p>		
35	<p>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</p>	Хэрэгжүүлсэн	<p>Компанийн дүрмийн 6.5-д хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй байхаар заасан. Компани нь нэмэлт хувьцаа гаргах бол хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэснээс бусад тохиолдолд Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлнэ.</p> <p>Мөн Компанийн дүрмийн 8.5.1 дэх хэсэг, 8.5.4 дэх хэсэгт зааснаар компанийн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах зорилгоор Компанийн дүрмийн өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох эрх, компанийн хэлбэрийг өөрчлөх эрх гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хуралд байна.</p>	2	100%
36	<p>9.5.Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээнэ.</p>	Хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 28 тоот тогтоолоор Компанийн Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулах журмыг баталж, цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Журмын хэрэгжилтийн хангалтыг компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусган ажиллах болно.</p>	2	100%
			ДҮН	10	100%



ТУЗ-ИЙН БОЛОН ТҮҮНИЙ ДЭРГЭДЭХ ХОРООДЫН 2023 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

“Инвекор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх байнгын үйл ажиллагаатай Эрсдэлийн удирдлагын хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо болон Нэр дэвшүүлэх хороотой.

“Инвекор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, Хороодын үйл ажиллагааны журамд заасны дагуу

Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын тус бүрийн 2023 оны ажлын гүйцэтгэлийн тайланг доорх хүснэгтэд үзүүлэв.

№	Хийгдсэн ажлууд	Давтамж/Хэлбэр	Гүйцэтгэл/Тайлбар
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал /Нийт 60 хурал/			
1	Компанийн тухай хууль болон Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд хамааруулсан хэлэлцэх асуудлуудыг тухай ээлжит бус хурлаар хэлэлцэв.	Ээлжит/Ээлжит бус Цахим болон биечлэн	Шаардлагатай зөвлөмж, анхааруулгыг өгч ажилласан.
Эрсдэлийн удирдлагын хороо /Нийт 15 хурал/			
1	Эрсдэлийн удирдлагын хорооны журмын дагуу Хорооны бүрэн эрхэд хамаарах үнийн дүн бүхий зээл олгох эсэх, зээлдэгчид тавигдах нэмэлт нөхцөлийг шийдвэрлэн ажилласан.	Эрсдэлийн тайланг улирал бүр, Зээл шийдвэрлэх хүсэлтийг тухай бүр	Шаардлагатай зөвлөмж, анхааруулгыг өгч ажилласан.
2	Компанийн Хууль эрсдэлийн удирдлагын газраас гаргасан эрсдэлийн тайлантай улирал бүр танилцаж, дүгнэлт гаргав.	Улирал бүр	Эрсдэлийн тайлантай танилцаж, шаардлагатай санал зөвлөмжийг хүргүүлсэн.
3	Өндөр эрсдэл бүхий зээлдэгч нарт Зээлийн гэрээгээр нэмэлт үүрэг хүлээлгэх, нэмэлт нөхцөлийг үг бүрчлэн зээлдэгчид тайлбарлах үүрэг даалгаврыг Зээлийн хороонд даалгаж ажилласан.	Тухай бүр	Хуулийн нэгжтэй хамтран гүйцэтгэв.
Аудитын хороо /Нийт 13 хурал/			
1	Дотоод аудитын газраас ирүүлсэн 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж, 2023 оны ажлын төлөвлөгөөг баталсан.	Жилд нэг удаа/цахимаар	Дотоод аудитын газрын үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай санал зөвлөмжийг хүргүүлсэн.

2	Дотоод аудитын газрын тайлантай улирал бүр танилцсан.	Улирал бүр/цахимаар	Дотоод аудитын газрын ажлын тайлантай танилцаж, шаардлагатай заавар зөвлөмжийг хүргүүлсэн.
3	Түүнчлэн “Инвескор ББСБ” ХК-тай харилцан хамаарал бүхий компаниудтай хийх сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эсэх асуудалтай тухай бүр танилцаж, холбогдох дүгнэлтийг гаргаж ажилласан.	Тухай бүр/биечлэн, цахимаар болон эчнээ санал хураалтаар	Аудитын хорооноос гарсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх дүгнэлтийг ТУЗ-ийн хуралд танилцуулж, эцсийн шийдвэрийг гаргуулсан.
4	Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан нөхцөлд санхүү бүртгэл болон үнэ шилжилтийн тайланд тусгах асуудлыг тухай бүр зөвлөсөн.	Тухай бүр	Холбоотой этгээдүүдийн хооронд хийгдсэн гэрээ хэлцэл, гүйлгээтэй холбоотой зөвлөмж

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлыг цахимаар зохион байгуулах, цахимаар санал авах процессыг тусгаснаар, гишүүдийн оролцоог бүрэн хангаж, Аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны хурлууд бүрэн ирц, оролцоотойгоор хуралдсан байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:



Б.БУД

/Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга/

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН

2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Инвекор ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга нь 2023 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

Үүнд:

Хийгдсэн ажлууд	Огноо	Давгамж/ Хэлбэр	Гүйцэтгэл/ Тайлбар
<p align="center">Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой</p> <p>Компанийн 2023 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зсхицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтлан хурлын зарыг өдөр тутмын сонин, Компанийн цахим хуудас болон мэдээний сайт-уудаар мэдээлэх, хувьцааны тархалтын мэдээг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс авах, хурлын материал хэвлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын системийн нэмэлт хөгжүүлэлтийг хийлгэх зэрэг хурал хуралдуулахтай холбоотой бүхий л бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>	<p align="center">2023 оны эхний хагас жил</p>	<p align="center">Ээлжит хурал/цахим</p>	<p>ХЭХ-ын тайланг бэлдэж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлэн, багалгаажуулсан.</p> <p>Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах ажилд компанийн бусад эрх бүхий албан тушаалтнуудын оролцоог хангахад онцгойлон анхаарал хандуулав.</p>
<p align="center">Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралтай холбоотой</p> <p>Компанийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зааврын дагуу холбогдох газар, нэгжүүдээс хэлэлцүүлэх гэж байгаа асуудалтай холбоотой материалыг хүлээн авч, хянах, шаардлагатай заавар зөвлөмжийг өгч ажилласан. Үүний дараа ТУЗ-ийн хурлын товыг зарлаж, хуралдуулсан. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой ТУЗ-аас баглагдан гарах тогтоолын төслийг бэлдсэн.</p>	<p align="center">2023</p>	<p align="center">60 удаагийн хурал /цахимаар, биечлэн, эчнээ санал хураалт авах замаар</p>	<p align="center">ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоолыг Компанийн холбогдох газар, нэгжүүдэд мэдээлж, хэрэгжилтийг хангуулсан.</p>
<p align="center">ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хуралтай холбоотой</p>			

<p>Достоод аудитын газраас ирүүлсэн 2021 оны үйл ажиллагааны тайлан, 2022 оны ажлын төлөвлөгөө болон бусад Газар, нэгжүүдээс ирүүлсэн Аудитын хороогоор хэлэлцүүлэх асуудлын танилцуулах санал, танилцуулга болон бусад холбогдох материалыг хянаж, Аудитын хорооны хурлын товыг зарлан хуралдуулсан.</p>	<p>2023</p>	<p>13 удаагийн /Цахимаар болон биечлэн</p>	<p>Аудитын хорооноос гарсан дүгнэлтийг ТУЗ-ийн хуралд танилцуулж, ТУЗ-ийн хурлын хэлэлцэх асуудалд оруулан ажиглав. Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах асуудлаар дүгнэлт гаргах тохиолдолд санал танилцуулж буй ажилтнуудад харьцуулсан судалгаа заавал танилцуулах шаардлага тавьж хэрэгжүүлж эхлэв.</p>
<p>ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хуралтай холбоотой</p>			
<p>Эрсдэлийн удирдлагын хорооны журмын дагуу Хорооны бүрэн эрхэд хамаарах үнийн дүн бүхий зээл олгох эсэх, зээлдэгчид тавигдах нэмэлт нөхцөлийг шийдвэрлэн ажилласан. Компанийн Хууль эрсдэлийн удирдлагын газраас гаргасан эрсдэлийн тайлантай улирал бүр танилцаж, дүгнэлт гаргав.</p>	<p>2023</p>	<p>15 удаагийн /Цахимаар болон биечлэн</p>	<p>Өндөр эрсдэл бүхий зээлдэгч нарт Зээлийн гэрээгээр нэмэлт үүрэг хүлээлгэх, нэмэлт нөхцөлийг үг бүрчлэн зээлдэгчид тайлбарлах үүрэг даалгаврыг Зээлийн хороонд даалгаж ажилласан.</p>
<p>Компанийн мэдээлэл нийлүүлэх үүргийн хэрэгжилт</p>			
<p>Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Үнэт цаас гаргагчаас олон нийтэд нээлттэй хүргэх мэдээллийн журмуудад заасны дагуу компаниас олон нийтэд нээлттэй мэдээлэх үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллав.</p>	<p>2023</p>	<p>МХБ-ын цахим систем СЗХ-ны цахим систем Компанийн албан ёсны вэб хуудас</p>	<p>Компанийн мэдээлэл, тайланг оруулахдаа холбогдох газар нэгжүүдтэй хамтран ажиллаж, мэдээллийн</p>
<p>Компанийн албан ёсны вэб хуудсыг шинэчлэх ажлын хэсэгт оролцон ажиллав.</p>	<p>2023</p>	<p>Компанийн албан ёсны вэб хуудас</p>	<p>Вэб хуудсанд Хувьцаа эзэмшигч, Компанийн тухай, Компанийн засаглал зэрэг бие даасан хэсгүүдийг хөгжүүлэх шаардлага тавин ажиллав.</p>
<p>Бусад</p>			

Гаднаас хөрөнгө оруулалт татах, хөндлөнгийн аудит хийх зэрэг үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн мэдээллийг өгөх байдлаар хамтран ажилласан.	2023	Тухай бүр	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу хэрэгжүүлэв.
Төлөөлөн удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бичиг хэргийг хөглөн явуулах, тогтоол, дүгнэлт, хурлын тэмдэглэлийг бэлдэх, хадгалах зэрэг үйл ажиллагааг тогтмол гүйцэтгэв	2023	Тухай бүр	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу хэрэгжүүлэв.
Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Б.Гандарь үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөж Б.Буд шинээр томилогдон, ажил хүлээлцэв.	2023.09.16		



Тайлан гаргасан:

Б.Буд

/Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга/

— 000 —

ТУЗ-н Ажлын Гүйцэтгэлийг Үнэлэх Үзүүлэлтүүд

ДОТООД ХЭРЭГЦЭЭНД

	Үзүүлэлтүүд	Зорилт	ТУЗ НБ /Бусад хороодын НБД		ТУЗ Дарга		ТУЗ Гишүүн	
			Эзлэх хувь	Гүйцэтгэл	Эзлэх хувь	Гүйцэтгэл	Эзлэх хувь	Гүйцэтгэл
1	Компанийн засаглалын гэрчилгээ	гэрчилгээ	15%		15%		15%	
2	Ажлын тайлан ХЭХ-д тайлагнах	тайлан	10%		10%		10%	
3	Хугацаа оролцсон ирц /+80%	ирц >90%	10%		15%		15%	
4	ТУЗ болон бусад хороодын хурлын бэлтгэл хангалт /100%	100%	15%					
5	ХЭХ-ийн ээлжит, ээлжит бус хурлын бэлтгэл хангалт /100%	100%	15%					
6	Хурлын шийдвэрийг боловсруулан, багтуулах, мэдээлсэн байдал /2 хонгчийн дотор	хурлаас хойш 2 хонг дотор	15%					
7	Компанийн дүрэм, ТУЗ-ын үйл ажиллагааны журмыг сахих ажилласан байдал /зөрчилтэй тохиолдол байхгүй байх	зөрчил тохиолдол 0	10%		10%		10%	
8	Компанийн стратеги болон дунд хугацаа, жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагааны бодлогыг цаг тухай бүрт нь багтаан баталсан байдал	100%			25%		15%	
9	ТУЗ-н дотоод үйл ажиллагаа, ажлын төлөвлөгөөний биелэлт	>95%	5%		15%		10%	
10	Компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах, Компанийн нэрийг хувийн ашиг сонирхлын зөрчил гаргаагүй байх	зөрчил тохиолдол 0					10%	
11	ТУЗ-ан болон бусад хорооны гишүүдэд сургалт зохион байгуулах	төлөвлөсөн сургалтын гүйцэтгэл >95%						
12	Хамрагдах шаардлагатай сургалтад бүрэн хамрагдсан байдал	>95%	5%		10%		15%	
			100%		100%		100%	



**ИНВЕСКОР ББСБ ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨДИЙН ГИШҮҮДИЙН
2023 ОНЫ СУРГАЛТЫН ТАЙЛАН**

№	Сургалтын агуулга	Давтамж	Хамрагдах гишүүн	Хариуцах эзэн/ Сургалт өгөх байгууллага	Биелэлт
1	Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт	ТУЗ-ийн гишүүн чөлөөлөгдсөн, оронд нь шинээр ТУЗ-ийн гишүүн томилогдсон тохиолдолд заавал суух сургалт	Шинээр томилогдож байгаа ТУЗ-ийн гишүүн	Компанийн засаглалын үндэсний зөвлөл, Компанийн засаглалын хөгжлийн төв болон бусад	Тус онд шинээр ТУЗ-ийн гишүүн томилогдоогүй болно.
2	Компанийн ТУЗ-ийн болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын журмын талаарх танилцуулах сургалт	Шинээр ТУЗ-ийн гишүүн томилогдсон тохиолдолд	Шинээр томилогдож байгаа ТУЗ-ийн гишүүн	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга	Тус онд шинээр ТУЗ-ийн гишүүн томилогдоогүй болно.
3	ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт	ТУЗ-ийн гишүүдийн санал болон ТУЗ-ийн гишүүний ажлын туршлага, мэдлэг чадварт үндэслэн тухай бүр	ТУЗ-ийн гишүүд	Холбогдох нэгж, байгууллага	Гишүүдийн цагийн хуваарийн боломжоос шалтгаалан зохион байгуулагдаагүй.
4	ББСБ-н Бизнесийн болон Ажилтны ёс зүйн дүрэм	Жилд нэг удаа заавал хамрагдахаар үүрэг болгосон.	ТУЗ-ийн гишүүд	ХУЭГ	Гишүүдийн цагийн хуваарийн боломжоос шалтгаалан зохион байгуулагдаагүй.
5	ББСБ-н Байгал орчин ногоон засаглал	Жилд нэг удаа заавал хамрагдахаар үүрэг болгосон.	ТУЗ-ийн гишүүд	ХУЭГ	12 сард зохион байгуулж, сургалтын үр дүнд ТУЗ-ийн дэргэдэх Тогтвортой байдлын хороог байгуулав.



Төлөвлөгөө бэлтгэсэн:

2023 оны 12 сарын 29-ний өдөр

**ИНВЕСКОР ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГЕИШҮҮХҮДИЙН
2024 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Сургалтын агуулга	Давтамж	Хамрагдах гишүүн	Хариуцах эзэн/ Сургалт өгөх байгууллага
1	Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт	ТУЗ-ийн гишүүн чөлөөлөгдсөн, оронд нь шинээр ТУЗ-ийн гишүүн томилогдсон тохиолдолд заавал суух сургалт	Шинээр томилогдож байгаа ТУЗ-ийн гишүүн	Компанийн засаглалын үндэсний зөвлөл, Компанийн засаглалын хөгжлийн төв болон бусад
2	Компанийн ТУЗ-ийн болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын журмын талаарх танилцуулах сургалт	Шинээр ТУЗ-ийн гишүүн томилогдсон тохиолдолд	Шинээр томилогдож байгаа ТУЗ-ийн гишүүн	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
3	Инвескор ББСБ ХК-ийн Төв Ази дахь бизнесийн үйл ажиллагаатай танилцах Study Tour	2024 оны 3-р улирал	ТУЗ-ийн гишүүд	Инвескор ББСБ ХК-ийн Төв Ази хариуцсан нэгж, ТУЗ-ийн ажлын алба хамтран зохион байгуулна
5	Компанийн засаглал болон ESG-ийн best practice, хэтийн төлөв	2024 оны 3-р улирал	ТУЗ-ийн дэргэдэх тогтвортой байдлын хорооны гишүүн	Холбогдох нэгж, эрх бүхий байгууллага